БАТЛАВ: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР ..../Х. ДАРМЕН/

БАЯННУУР СУМЫН 5-Р БАГТ ШИНЭЭР

БАРИГДАХ ДЭД СТАНЦЫН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2025.03.31 **№25/38** **Өлгий сум**

1.Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээдийн нэр, хаяг	БАРИЛГА ЗАХИАЛАГЧЫН АЛБАНЫ ДАРГА Ш.ЖАНИМХАН
2.Техникийн нөхцөл хүссэн газрын байршил	Баян-Өлгий аймаг Баяннуур сум.5-р баг
3.Ажил үйлчилгээний зориулалт	Айл өрхийн цахилгаан хангамж
4.Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	БЗА-ны даргын 2025 оны 03-р сарын 24-ны 67/25 тоот хүсэлт, ЦШСГ-ын цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн 2025 оны 03-р сарын 31-ны өдрийн хурлын шийдвэрийн тэмдэглэл
5.Олгосон чадал	1x250кВА
6.Тоолуур	RS 485 интерфейсийн шаардлага хангасан, "IEC61107", "IEC62056" холболтын протоколтой, Монгол улсын Стандарт, хэмжил зүйн газраар баталгаажиж ашиглахыг зөвшөөрсөн, санах ой бүхий 0.2 нарийвчлалтай балансын мэйжүрмент маркийн ухаалаг тоолуур буюу 0.4кВ-ын дэд станцын мэдээлэл цуглуулах дата концентратортай PLC буюу хүчдэлийн шугамаар холбогдож мэдээллээ илгээдэг байх. Мөн GSM сүлжээгээр мэдээлэл дамжуулах сим картны ороллттой тоолуурын аль нэгийг тавих. Хэрэглэгчдийн ухаалаг тоолуураас шаардлагатай параметрүүдийг ямар нэгэн нэмэлт холболтын кабель шаардахгүй PLC буюу хүчдэлийн шугамаар дамжуулан авч байдаг төхөөрөмж бөгөөд 0.4кВ-ын хүчдэлийн түвшинтэй дэд станцын толгой тоолуурын хамт байрлана. Дата концентратор нь үүрэн холбооны GSM сүлжээний 3G, 4G хурдаар мэдээллийг ухаалаг тоолуурын төв серверт илгээх ба нэмэлт антеннатай байна.

7.Гүйдлийн трансформатор	Тооцооны гүйдлийн трансформатор, хэмжүүрийн гүйдлийн трансформаторыг тус тусад нь монтажлах, тооцооны тоолуур. гүйдлийн трансформатор нь Монгол улсын хэмжил зүйн загварын туршилтаар баталгаажсан байх ба хэмжил зүйн баталгааанд орсон байх.
8.Холбогдох цэг	Баяннуур сумын АТП-1 дэд станц тэжээгдэж байгаа төгсгөлийн баганаас салбарлан хуурай салгуур тавьж,1300м 10кВ-ын ЦДАШ татаж 10/0.4кВ-ын 250кВА чадалтай агаарын дэд станц барих.
9. **Тусгай заалтууд**	**9.1 Шинээр баригдах агаарын дэд станцын цахилгаан дамжуулах агаарын шугам:** 9.1.1 Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг одоо болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд ЦШСГ-тай зөвшилцөн сонгох. 9.1.2 Шинээр баригдах 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS6522:2015 стандартын шаардлага хангасан байх. 9.1.3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын чадал нь АС-50 маркийн утаснаас доошгүй байх. 9.1.4 Дамжуулагчын хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгох. 9.1.5 Цахилгаан дамжуулах агаарын шугам нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох. 9.1.6 10кВ-ын ЦДАШ-ын багануудад газардуулга хийх. 9.1.7 Холбогдох цэгт хуурай салгуур тавьж өгөх. **9.2 Шинээр 10/0.4кВ-ын агаарын дэд станц суурилуулах.** 9.2.1 Шинээр баригдах 10/0.4кВ-ын дэд станц нь MNS 6521:2015 стандартын шаардлага хангасан байх. 9.2.2 10/0.4кВ-ын дэд станц нь 1*250кВА хүчин чадалтай трансформатортай байх бөгөөд олон улсын IEC 60076-10 стандартын шаардлага хангасан байх. 9.2.3 10/0.4кВ-ын 1ком 1*250кВА хүчин чадалтай дэд станцын тоног төхөөрөмжийн суурилуулалт болон

газардуулгыг техник ашиглалтын норм, дүрмийн дагуу хийж өгөх.

9.2.4 Шинээр суурилуулж буй тоноглолууд нь тухайн орчны цаг уурын нөхцөл, далайн түвшний өндөрлөг, IEC стандарт, техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байх, нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу +-10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.

9.2.5 Галын хор, щит, самбар, путкыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах.

9.2.6 Уг дэд станц нь агаарын дэд станц ба 1*250кВА чадалтай трансформатортай байх ба 0.4кВ тал нь 6-н гаргалгааны самбартай байх.

9.2.7 Техникийн нөхцөлийн дагуу суурилуулах тоноглолууд, шугам нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх ба шинэ тоноглолоор хангагдсан байх.

9.2.8 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, техникийн нөхцөл олгосон ба ашиглагч байгууллагад хүлээлгэж өгөх.

9.2.9 Дэд станцын гадна хашаа хийх.

10.Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын зураг төсвийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэж, тухайн орон нутгийн ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх.

10.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах.

10.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Цахилгаан байгууламжын угсралтын дүрэм" /2003 он/, Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх.

10.4 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад

хэрэглэгчийг нэмж болох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

10.5 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг,шуурхай ажиллагааны нэр, анхдагч болон хоёрдогч хэлхээний зургийг Цахилгаан шугам сүлжээний газартай зөвшилцөх.

19. Эрчим хүчний сайдын 2013 оны 01-р сарын 04-ны өдрийн 03-р тушаалын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам"-ын 5 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

5.2 Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

5.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон.

5.2.2 Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон.

5.2.3 Техникийн нөхцлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд.

5.2.4 Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.

5.2.5 Техникийн нөхцөл олгосны суурь хураамж болох 165000 төгрөг төлсөн байх.

5.2.6 Техникийн нөхцөл хоёр жилийн дотор хүчинтэй.

5.2.7 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.

Боловсруулсан: Ашиглалтын инженер...../А.Аблайхан/

Борлуулалтын инженер...../Е. Нурлан/

Горим тооцооны инженер...../Б. Мейрам/

ХҮСЭЛТ ГАРГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БУЮУ ХЭРЭГЛЭГЧ:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн хүчингүй болгох заалттай танилцсан эсэх

.....тийм

Нэр .....

Регистрийн дугаар

Холбоо барих утас

Огноо:.....

.....үгүй

Гарын үсэг .....

.....

.....